



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эзэн төр ХХК-ийн “Мөрөн” зочид буудлын 17/254, Нью жаско ХХК-ийн “Марс” зочид буудлын 17/272, Ти энд жи ХХК-ийн “Нью вэст” зочид буудлын 17/251, Хонконглүюу ХХК-ийн “Хонконг” зочид буудлын 17/233, Монгол цонх плаза ХХК-ийн “Монгол цонх” дэн буудлын 17/256, Эрмон билэг ХХК-ийн “Эрмон билэг” дэн буудлын 17/255, тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

1150500307

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Х.Содномдэмбэрэл/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 11
сарын 07 өдрийн А/86 дугаар
тушаалын нэгдүгээр хэвсрэлт

5284025 СБТ 2926 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.11.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Эзэн төр ХХК	2034654	Мөрөн	БГД-ийн 8-р хороо Дилав хутагт Жамсранжавын гудамж 1 тоот
2	Нью жаско ХХК	5168848	Марс	БГД-ийн 17 хороо Жалханз хутагт Дамдинбазарын гудамж 66-01
3	Ти энд жи ХХК	5819105	Нью вэст	БГД-ийн 10 хороолол, 5-р хороо 91 байр
4	Хонконглүүюу ХХК	5148391	Хонконг	СХД-ийн 13 хороо, Москва 10-49
5	Скай сэн сон ХХК	5465109	Кёкүшю	БГД-ийн 6-р хороо Кёкүшү тауэр 17 давхар

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 11
сарын 07 өдрийн А/86 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ-8926 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.11.07

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монгол цонх плаза ХХК	5370434	Монгол цонх	БГД-ийн 3-р хороо 2-р хороолол замчдын гудамж 6/1
2	Эрмон билэг ХХК	2585022	Эрмон билэг	БГД-ийн 17-р хороо 4-р хороолол Эрмон билэг байр
3	Мөнхням шигтгээ ХХК	5042801	ЮБ-17	ЧД-ийн 13-р хороо
4	Азар-эрдэнэ ХХК	5477352	Смайл	БГД-ийн 11-р хороо Зүүн нарангийн 1-1-А тоот
5	Их баяннуур ХХК	2069385	Өнөр төв	СХД-ийн 13-хороо 1-р байрны баруун талд 195 тоот барилга